



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Увс аймгийн “Шинэ-Улаангом” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:

В.Дарханбаатар

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын
хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны дарга;

Гишүүд:

Г.Дэлгэрмаа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын
хэлтсийн мэргэжилтэн.

Г.Нямдаваа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын
хэлтсийн мэргэжилтэн.

2. Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3. Албан хаагчдын томилолтын зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

4. Албан хаагчийн унаа, томилолтын зардлыг зохих журмын дагуу тооцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Н.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

5. Ажлын хэсгийн нэгдсэн санал, дүгнэлтийг 2023 оны 10 дугаар сарын 23-ны дотор багтаан танилцуулахыг Ажлын хэсэг / В.Дарханбаатар /-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132013688

ТӨБЗГ тушаал-/2023

Төрийн өмчийн бодолго, зохицуулалтын
газрын даргын 2023 оны 10 дугаар сарын
02 өдрийн 4/24 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг: Зорилго

Увс аймгийн "Шинэ-Улаангом" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, Аймгийн ИТХ, Засаг даргад тус үйлдвэрийн газарт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий Ажлын хэсэг энэхүү удирдамжийг баримтална.

Хоёр: Хийгдэх ажлын чиглэл

1. Увс аймгийн "Шинэ-Улаангом" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай газар дээр нь танилцах;

2. Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас ирүүлсэн төлөвлөгөөний дагуу тус үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжрахгүй, өр авлага нэмэгдэх, алдагдал буурахгүй зөрчил дутагдал гарч байгаа тал дээр дүн шинжилгээ хийсэн материалуудтай танилцах;

3. Тус орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааг сайжруулах, цаашид авч хэрэгжүүлэх авах арга хэмжээний талаар санал боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх.

Гурав: Үр дүн, хугацаа

Ажлын хэсгийн тайлан, цаашид авах арга хэмжээний талаарх санал дүгнэлтээ 2023 оны 10 дугаар сарын 23-ны дотор багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагад танилцуулах.

.....000.....

**ОРОН НУТАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ УДИРДАМЖ,
ЗАРДЛЫН ТӨСӨВ**

Нэг. Ерөнхий мэдээлэл

Албан томилолтын ажлын зорилго, чиглэл:

Увс аймгийн "Шинэ-Улаангом" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, тус үйлдвэрийн газрын талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Аймгийн ИТХ, Засаг даргад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх.

Албан томилолтоор ажиллах хугацаа:

2022 оны 10 дугаар сарын 10-ний өдрөөс ажлын 4 хоногийн хугацаанд гүйцэтгэнэ.

Албан томилолтоор ажиллах нэгж: Увс аймагт

Хоёр. Албан томилолтоор хийж гүйцэтгэх ажил үүрэг

Увс аймгийн "Шинэ-Улаангом" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас ирүүлсэн төлөвлөгөөний дагуу тус үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжрахгүй, өр авлага нэмэгдэх, алдагдал буурахгүй зөрчил дутагдал гарч байгаа тал дээр дүн шинжилгээ хийсэн материалуудтай танилцах, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааг сайжруулах, цаашид авч хэрэгжүүлэх авах арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар санал боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлаар.

д/д	Зардлын төрөл	Төсөвлөсөн /төгрөгөөр/	Хянасан (төгрөгөөр)
Тээврийн зардал / 100 км-т 20 л Бензин/А-92/, 1л түлш хөдөө орон нутагт 2800 төг/ Томилолт 3 албан хаагч 4 хоног 1 машин.			
1	Унааны зардал: Увс аймаг явах ирэх унааны зардал /1300*2=2600.00 км/ 2600.00 км х 2800 х 20=1,456,000.00	1,456,000.00	
2	Байр: 3 хүн х 4 хоног х 90 000= 1.080,000.00 Хоол: 3 хүн х 4 хоног х 28 000= 336,000.00	1,416,000.00	
Нийт дүн:		2,872,000.00	

Тоогоор /2,872,000.00 төгрөг/, үсгээр / хоёр сая найман зуун далан хоёр мянган/ төгрөг.

Тайлбар: Сангийн сайдын 2022 оны 120 тоот тушаалаар батлагдсан томилолтын зардлын нормативыг үндэслэн тооцов.

.....000.....